



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛГАЧ АГЕНТЛАГ  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

14191 Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 8аа тал 14, б/н  
Утас 262449 266246 Факс 997831 997834

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ Д.СҮМЬЯАБАЗАР ТАНАА

2022.04.12 № 1/286

тагай -ни №

Г

Дэмжлэг хүсэх тухай


Монгол Улсын засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг-Биийн тамир, спортын улсын хороо болгон өөрчлөн байгуулагдсан.

Биийн тамир, спортын улсын хорооны байр болох "Спортын төв ордон"-нд 2009 оноос Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургууль байрлан сургалт-хүмүүжлийн үйл ажиллагаага явуулж байна.

Тус сургуулийн сургалт-хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж буй Спортын төв ордны байрыг Монгол Улсын Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2012 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн "Барилгын төлөв байдлын тухай" 07-11/542 дугаар дүгнэлтээр "спортын ордны барилгыг цаашид ашиглалтын шаардлага хангахгүй" гэж тодорхойлсон.

Спортын төв ордон нь 1958 онд спортын тэмцээн зохион байгуулах, бэлтгэл-дасгалжуулалтын үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдсан хэдий ч одоогоор Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургууль байрлан сургалт-хүмүүжлийн үйл ажиллагаа явуулснаар зориулалтын дагуу бүрэн ашиглах боломжгүй болсон. Тодруулбал, ерөнхий боловсролын сургууль нь гадаад болон дотоод орчны стандартын шаардлага хангахгүй зориулалтын бус байранд сургалт-хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүсгэж байна.

Иймд 2021-2022 оны хичээлийн жилээр дуусгавар болгон Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургуулийг Спортын төв ордны хичээлийн байраар хангах боломжгүй болсон бөгөөд тус сургуулийг өөрийн сургалтын байртай болох хүртэлх хугацаанд түр байршуулан сургалт-хүмүүжлийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг судлан шийдвэрлэж бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү.



Ц.ШАРАВЖАМЦ